



GENCO TOUR
BUREAU JSC

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017 он

1. КОМПАНИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл

Нэр: “Женко тур бюро” Хувьцаат компани

Хаяг : Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-5, Баянгол зочид буудал, оффис-4

Утас: 70120202, 91961900, 94011900

Электрон хаяг: info@genco-tour.mn

1.1.Компанийн товч танилцуулга, үйл ажиллагааны чиглэл

“Женко Тур Бюро” Хувьцаат Компани нь 1997 онд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан бөгөөд аялал жуулчлалын салбарын тэргүүлэгч компаниудын нэг юм.

Эрхэм зорилго, уриа

Гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн, олон улсын түвшинд үнэлэгдэх үндэсний тур оператор компани болох.

Бидний уриа:

Тухлах газрыг та сонго Туулах замыг бид хөтөлье

Үйл ажиллагааны чиглэл:

Манай компани нь аялал жуулчлалын үйл ажиллагааны чиглэлээр доорх үйлчилгээнүүдийг гадаад, дотоодын аялагч, жуулчдад үзүүлж байна. Үүнд:

- Дотоод, Гадаад аялал
- Дотоод, Гадаадын шууд нислэг захиалга
- Бүх төрлийн тээврийн билет захиалга
- Зочид буудлын өрөө захиалга
- Гэр жуулчны бааз
- Уламжлалт баяр наадам зохион байгуулах
- М.І.С.Е Хурал, семинар зохион байгуулах

Компани нь дотоодын өндөр зэрэглэлийн 10 гаруй зочид буудал, 20 гаруй ресторан, зоогийн газар, байгалийн үзэсгэлэнт газрууд бүхий 50 гаруй жуулчны бааз, бусад үзвэр үйлчилгээ, соёл амралтын томоохон газруудтай хамтран ажиллаж байна. Мөн Ази, Европын орнуудтай, тэр дундаа, Япон, Сингапур, Солонгос, Хятад, Орос, Германы аялал жуулчлалын бизнесийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Компани нь дотоодын болон олон улсын чанартай аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт жил бүр амжилттай оролцон, жилээс жилд өөрийн гадаад харилцаагаа өргөжүүлсээр байна.

1.2. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт

Компанийн 2017 оны борлуулалтын орлого, цэвэр ашгийн үзүүлэлт болон 2018 оны төлөвлөгөө.



1.3 Үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан

1.3.1 Маркетингийн тайлан

Зорилтот зах зээлд бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулахдаа маркетингийн судалгаа болон багаар ярилцан идэвхижүүлэлтийн сувгийг тодорхойлж, борлуулалтыг нэмэгдүүлэн ажилсан.

Олон улсын зах зээлд “Женко Тур Бюро” ХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ, цогцолборуудын мэдээлэл, тэр дундаа дотоод аяллын мэдээллийн урсгалыг сайжруулах, хамтран ажиллах аяллын компаниудтай нягт уялдаа холбоотой ажиллах бодлого баримтлан ажилласан болно. Бид улирал бүр тухайн бүтээгдэхүүн үйлчилгээн дээр маркетингийн төлөвлөгөө гаргаж алба хэлтэс дотроо хэлэлцүүлэг өрнүүлэн, төлөвлөгөөгөө сайжруулж удирдлагаар батлуулан, багаар ажилласан.

“Top Resa 2017” үзэсгэлэн



2017.09.26-29 зохион байгуулагдсан энэхүү үзэсгэлэнд “Женко Тур Бюро” ХК гурав дахь жилдээ оролцон аяллын бүтээгдэхүүн үйлчилгээгээ амжилттай танилцуулан оролцлоо.



ITM-2017 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

Монголын аялал жуулчлалын салбарын нэгдсэн арга хэмжээ “Мишээл экспо”-дээр 18 дахь жилдээ зохион байгуулагдсан бөгөөд "ЖЕНКО ТУР БЮРО"ХК ерөнхий ивээн тэтгэгчээр оролцон бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулсан.



| № | ЭВЕНТИЙН НЭР | ХУГАЦАА |
|----|-----------------------------------|--------------|
| 1 | Шинийн Нэгний Нар Харах Аялал | 2017.02.16 |
| 2 | Мартын 8 Эмэгтэйчүүдийн Баяр | 2017.03.08 |
| 3 | Түүхийн Лекцтэй Аялал | Сар бүр |
| 4 | Номадик Фешн шоу | 2017.07.21 |
| 5 | Чингис хааны үрс хүүхдийн баяр | 2017.06.01 |
| 6 | Pre-party of Hunnu Music Festival | 2017.06.11 |
| 7 | Хүннү Мьюзик фестиваль | 2017.06.17 |
| 8 | Бөөгийн тахилга | 2017.06.25 |
| 9 | Эр бор харцага бэсрэг наадам | 2017.07.26 |
| 10 | Галын тахилга | 2017.07.26 |
| 11 | Genco Mongolian Bike Challenge | 2017.09 сар |
| 12 | Монгол Хурим | 2017.10 сар |
| 13 | Чингис Фестиваль | 2017.11 сард |
| 14 | Түүхэн Жүжиг | 2017.11 сар |
| 15 | Мөнгөн Үдэш | 2017.12 сар |



1.3.2 Хүний нөөцийн тайлан


Мэргэжлийн ур чадварлаг боловсон хүчнээр хангаж хүний нөөцийн төлөвлөлт, стратеги бодлого, чиглэлийн оновчтой тогтолцоог бүрдүүлэн ажилласан.

Мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангах, тэднийг сургаж хөгжүүлэх, мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээ тогтоон барьж үлдэх, гаднаас чадварлаг ажилчдыг татах, мэргэжлийн боловсон хүчнээр баг бүрдүүлж ажилласан.


Компанид шаардлагатай дүрэм журмууд цогцоороо шинэчлэгдэн мөрдөгдөж эхэлсэн бөгөөд шинээр орж буй ажилтнуудад зориулсан дасан зохицох хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлсэн. Ажлын хүрээнд ажилтнуудын ажлыг бодитойгоор үнэлэн түүнд нь

тохирсон урамшуулал олгох зорилгоор томоохон байгууллагуудын хэрэгжүүлдэг КРІ системийг амжилттай нэвтрүүлж эхэлсэн. Борлуулалтаас хамааран бонус олгох журмыг боловсруулсан.

1.3.3 Аяллын тайлан



2017 онд манай компани азийн зах зээлийг хөгжүүлэх ажилыг эрчимтэй хэрэгжүүлсэний үндсэн дээр Солонгос, Япон улсын 400 гаруй жуулчин хүлээн авсан.



Ази зах зээл (Солонгос, Япон)-ийн нийт борлуулалтын дүн : 181,206 USD



2017 онд манай компани багц аялал болон захиалгат тусгай аялал нийлсэн 1081 жуулчинд үйлчилсэн. Үүний

Багц аялал : 446 жуулчин

Захиалгат аялал: 635 жуулчин

2. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА


“Гэрэлт ирээдүй” Сайн үйлсийн аян

Санаачлагч: “Женко Тур Бюро” ХК-ийн хамт олон бид улс орныхоо өмнө хүлээсэн нийгмийн хариуцлагаа ухамсарлан ирээдүй хойч үе болсон хүүхэд багачуудынхаа төлөө сайн үйлсийн аянг өрнүүлж ажиллаа.

Аяны зорилго: Энэхүү аяны зорилго Чингис хааны морьт хөшөөгөөр аялан нэгэн өдрийг их түүхээрээ бахархах үндсэний соёл, түүх дурсгалыг түгээн дэлгэрүүлэх түүгээр дамжуулан түүхийн боловсрол олгох нэгэн өдрийг их түүхийн жимээр аялуулах зорилоготой.



Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр Женко Тур Бюро” ХК олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан нийгмийн хариуцлагийн хүрээнд өрх толгойлсон эмэгтэйчүүдэд хандивын гар сунгав. Түүнчлэн энэ өдөр ирсэн бүх эмэгтэйчүүддээ “Чингисийн Морьт Хөшөөт Цогцолбор” болон “13-р зуун цогцолбор”-оор тус тус үнэгүй үзвэр үйлчилгээ үзүүлэх боломжийг олголоо.



Хүүхдийн баяр



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр буюу жил бүрийн 6-р сарын 01-ний өдрийг уламжлал болгон бид “Чингис хааны морьт хөшөөн” дээр өхөөрдөм хөөрхөн үрстэйгээ хамт тэмдэглэдэг билээ. Энэ өдөр “Чингис Хааны Морьт Хөшөөт Цогцолбор” дээр болдог “Чингис Хааны Үрсийн Баяр” арга хэмжээнд асрамжийн газрын хүүхдүүдийг хотоос зайтай эрүүл агаарт авчран олон сонирхолтой уралдаан тэмцээн, үзвэр үйлчилгээ болон тоглолтыг үзүүлэн гарын бэлэг өгдөг байгаа. Мөн энэ өдрийн арга хэмжээнд 16-аас доош насны хүүхэд бүр үнэ төлбөргүйгээр тоглолт болон үзвэр үзэх боломжийг олгон эх үрсийн баяраа үлгэрийн баатруудтай хамт мартагдахааргүй хөгжилтэй өнгөрүүлдэг.

Тухлах газрыг та сонго Туулах замыг бид хөтөлбө

Ахмадын өдөр

“Чингисийн Морьт Хөшөөт Цогцолбор” болон “13-р зуун цогцолбор”-оор тус тус үнэгүй үзвэр үйлчилгээ үзүүлэн халуун сэтгэлийн хандиваа өгдөг байгаа.



Орон нутагтай хамтарсан нийгмийн хариуцлага

Төв аймгийн Эрдэнэ сумын нутгийн удирдлагын ордонтой хамтран сургууль болон сумдын амжиргааны төвшин доогуур өрх гэрд 5 ханатай иж бүрэн гэр хандивласан. Мөн сургууль цэцэрлэгийн засвар үйлчилгээнд мөнгөн тусламж үзүүлэн хамтран ажиллаа.

3. УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ


3.1. Гүйцэтгэх удирдлага

| № | Нэрс | Албан тушаал |
|---|------------------|------------------------|
| 1 | Баттулга Намуун | Гүйцэтгэх захирал |
| 2 | Б. Түмэндэмбэрэл | Ерөнхий нягтлан бодогч |

3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичиг

| № | Нэрс | Албан тушаал | Компанид хувьцаа эзэмшдэг эсэх |
|----|------------------------|---------------------------|--------------------------------|
| 1 | Данзан Даянбилгүүн | ТУЗ-ийн дарга | - |
| 2 | Бүрэнмэнд Лхагвадорж | ТУЗ-ийн ердийн гишүүн | - |
| 3 | Баттулга Намуун | ТУЗ-ийн ердийн гишүүн | 3.5% |
| 4 | Бадаан Батбаатар | ТУЗ-ийн ердийн гишүүн | - |
| 5 | Дашцэрэн Даваасүрэн | ТУЗ-ийн ердийн гишүүн | 6.85% |
| 6 | Халтмаа Цэндбаяр | ТУЗ-ийн ердийн гишүүн | - |
| 7 | Жамьянсүрэн Баттөр | ТУЗ-ийн хараат бус гишүүн | - |
| 8 | Тэгшээ Одням | ТУЗ-ийн хараат бус гишүүн | - |
| 9 | Балжинням Амарсанаа | ТУЗ-ийн хараат бус гишүүн | - |
| 10 | Даваасамбуу Шүрэнцэцэг | ТУЗ-ийн нарийн бичиг | - |

3.3. 5 хувиас дээш хувь эзэмшигчдийн мэдээлэл



3.4. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан

“Женко тур бюро” ХК-ийн 2017 оны 04 сарын 28 ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулж хурлаас одоогийн ТУЗ-ийн гишүүд сонгогдон ажилласан. Шинээр томилогдсон ТУЗ-нь 2017 оны 05 сарын 15-ны өдөр 66.66 хувийн эрцтэйгээр хуралдан ТУЗ-ийн даргаар Д.Даянбилгүүн-г 100 хувийн саналаар сонгосон. Мөн дараах байдлаар ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдийг томилсон.

| № | Хороо | Гишүүнийн нэрс | Албан тушаал |
|---|-------------------------|----------------|---------------------------|
| 1 | Нэр дэвшүүлэх хороо | Ж.Батгөр | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | | Б.Амарсанаа | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | | Б.Лхагвадорж | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| 2 | Аудитын хороонд | Д.Даваасүрэн | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| | | Т.Одням | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | | Ж.Батгөр | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| 3 | Цалин урамшууллын хороо | Б.Амарсанаа | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | | Т.Одням | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | | Б.Намуун | ТУЗ-ийн ердийн гишүүн |

2017 онд ТУЗ-нь 4 удаа ирц бүрэлдүүлэн хуралдаж холбогдох шийдвэр зөвлөмжийг гарган ажилласан.

Аудитын хороо нь компанийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт хийх хөндлөнгийн аудитаар “Шинэ их тэрбум аудит” ХХК-г сонгон ажиллуулсан.

Нэр дэвшүүлэх хороо нь 2018 оны 04 сарын 28-нд болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-д шинээр сонгогдох нэр дэвшигчдийг дараах байдлаар сонгон дэвшүүлж ХЭХ-аар санал хураан томилно.

| № | Ердийн гишүүнд нэр дэвшигчид | № | Хараат бус гишүүнд нэр дэвшигчид |
|---|------------------------------|---|----------------------------------|
| 1 | Д.Даянбилгүүн | 1 | Т.Одням |
| 2 | Б.Лхагвадорж | 2 | Б.Амарсанаа |
| 3 | Б.Намуун | 3 | Ц.Энхтуяа |
| 4 | Х.Цэндбаяр | | |
| 5 | Б.Мянганбаяр | | |
| 6 | Д.Даваасүрэн | | |

3.5 ТУЗ-ийн компаний 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт

“ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

“Женко Тур Бюро” ХК-ийн 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн 9 гишүүн дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгогдон, Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирлээ.

ТУЗ-ын дарга: Д.Даянбилгүүн

ТУЗ-ын гишүүд: Б.Лхагвадорж, Б.Батбаатар, Х.Цэндбаяр, Ж.Баттөр, Б.Амарсанаа, Д.Даваасүрэн, Т.Одням, Б.Намуун

2017 онд Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт 4 удаа хуралдаж компанийн улирал бүрийн хийгдсэн ажил болон хийгдэх ажлын төлөвлөгөөтэй танилцаж зохих зөвлөгөөг өгсөөр ирсэн.

Санхүү тайлангийн тухай

2018 оны хөндлөнгийн аудитаар “Шинэ Их Тэрбум Аудит” ХХК-г төлөөлөн удирдах зөвлөлөөс шинээр сонгон гэрээ байгуулан ажилласан.

Тус аудит нь 2017 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийж гүйцэтгэсэн.

Аудитын дүгнэлтээр компанийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн хэмээн дүгнэсэн.

Үйл ажиллагааны тухай

Компани нь 2017 онд 167,6 сая төгрөгний ашигтай ажилласан нь 2016 оны алдагдалтай үзүүлэлтээс 134 хувиар өссөн байна.

Ашиг орлогоо нэмэгдүүлэх үүднээс гадаад аяллаа идэвхжүүлэн 2017 онд компани азийн зах зээлийг хөгжүүлэх ажлыг эрчимтэй хэрэгжүүлсний үндсэн дээр Солонгос, Япон улсын 400 гаруй жуулчин хүлээн авч борлуулалтын орлогоо 181,206 USD-ээр нэмэгдүүлсэн. Мөн 2017 оны 4 болон 9 дүгээр сард Францад аялал жуулчлалын хамтын ажиллагаа хөгжүүлэх ажил хэргийн уулзалтууд хийсэн байна. Trip addekua, Ailleur Voyage, Nomade aventuer, Spiritzen Tourism, Terre Constellee, Fram Travel компаниудтай хэлэлцээ хийж хамтран ажиллахаар тохиролцон 2018 онд Франц улсын зах зээлээс 100

жуулчин хүлээн авахаар урьдчилсан байдлаар захиалга хүлээн аваад байна. Францын зах зээлээс аялахад бэлэн болсон борлуулалтын төлөвлөгөөг 292,393,723-д хүргэсэн байна. Чингисийн хөшөө цогцолборын борлуулалтын орлого 2017 оны төлөвлөгөө 119 хувийн биелэлттэй буюу 1,5 тэрбум хүрсэн бол 13-р зуун цогцолборын борлуулалтын орлого 80.7 хувийн төлөвлөгөөний биелэлттэй буюу 288 сая болсон байна. Үүнээс дүгнэхэд Чингисийн хөшөө цогцолборыг үзэхээр очсон жуулчдыг 13-р зуун цогцолбор луу явуулах тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй юм. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаа эзэмшигчдийн дэвшүүлсэн засвар үйлчилгээтэй холбоотой санал болон үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийн дагуу Чингисийн морьт хөшөө болон 13-р зуун цогцолборт засвар шинэчлэл хийхээр төлөвлөн, засвар үйлчилгээний дэлгэрэнгүй жагсаалт, тооцооллыг гаргаж 2018 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Өнгөрсөн онд гадаад аялал жуулчлалыг хөгжүүлэхээр ази, европын улс орнуудтай хамтран ажиллах гэрээг байгуулж Монгол улсыг зорин ирэх жуулчдын тоог өсгөх эхлэлийг тавьсан нь цаашдын үйл ажиллагаа, борлуулалтад эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.

Мөн дэлхийн аялал жуулчлалын байгууллагын гаргасан судалгаанд үндэслэн байгууллагынхаа хүчин чадлыг нэмэгдүүлэхээр засвар үйлчилгээ шинэчлэлийг хийхээр төлөвлөсөн нь ихээхэн авууштай юм.

Дээрх үзүүлэлтүүдээс дүгнэхэд “Женко тур бюро” ХК-ийн гүйцэтгэх удирдлагыг 2017 онд ажилчид хамт олноо сайн удирдан зохион байгуулж, ашгийн хэмжээг нэмэгдүүлж ажилласан байна гэж дүгнэж энэхүү дүгнэлтийг компанийн тухай хуулийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга: Д.Даянбилгүүн

4. САНХҮҮ ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Санхүү байдлын тайлангийн гол үзүүлэлтүүд /2016 онтой харьцуулав/

| Үзүүлэлт | 2016 он | 2017 он |
|---------------------------------------|---------------------|---------------------|
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 836,700.7 | 859,038.4 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 9,926,696.5 | 9,650,454.5 |
| Нийт хөрөнгийн дүн | 10,763,397.2 | 10,509,492.9 |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 1,616,235.7 | 1,457,789.6 |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | 924,977.9 | 661,903.1 |
| Эздийн өмчийн дүн | 8,222,183.6 | 8,389,800.2 |
| Өр төлбөр ба эздийн өмчийн дүн | 10,763,397.2 | 10,509,492.9 |

4.2. Борлуулалтын орлогын үзүүлэлт /2016 онтой харьцуулав/

| Үзүүлэлт | 2016 он | 2017 он |
|---|-------------------|------------------|
| Борлуулалтын орлого (цэвэр) | 1,973,292.7 | 3,462,937.2 |
| Борлуулалтын өртөг | 1,629,190.5 | 3,011,613.8 |
| Нийт ашиг (алдагдал) | 344,102.2 | 451,323.4 |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | -487,055.7 | 188,953.7 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | -491,612.3 | 167,616.6 |

2017 онд “Женко тур бюро” Хувьцаат компани 167.6 сая төгрөгний ашигтай ажилласан бөгөөд энэ 2016 онд жилийн эцсийн үзүүлэлтээс 134 хувийн өсөлттэй үзүүлэлт юм. Мөн ажлын хамт олны хүчин чармайлтын үр дүнд борлуулалтын орлогын өсөлт 75,4иар өссөн. Ашигт ажиллагаанд нөлөөлсөн гол үзүүлэлт нь гадаад валютын ханшийн зөрүүний гарз 2016 онд 506.7 сая байснаас 2017 онд 20.6 саяын олзтой болсонтой холбоотой юм.

4.3. Санхүүгийн харьцаа үзүүлэлт /2016 онтой харьцуулав/

| | 2016он | 2017он |
|---|-------------|------------|
| Нийт хөрөнгийн өгөөж | -0.046 | 0.016 |
| Эздийн өмчийн өгөөж | -0.060 | 0.020 |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) | -4.916 | 1.676 |
| Зах зээлийн үнэлгээ /2017-12-31ны байдлаар/ | 6.06 тэрбум | 6.8 тэрбум |
| Бодит үнэ | 82.222 | 83.898 |
| Зах зээлийн ханш / төгрөг / | 68 | 60.62 |
| Зах зээлийн үнэ бодит үнийн харьцаа /ЗЗҮ/БҮ | 0.827 | 0.723 |
| Үнэ ашгийн харьцаа (P/E) | -13.832 | 36.166 |

EPS-буюу нэгж хувьцаанд ногдох ашиг гэдэг нь компанийн нэгж хувьцааны цаана хэдэн төгрөгний ашиг олж байгааг харуулдаг.

ЗЗҮ/БҮ-нь тухайн нэгж хувьцаанд ногдох бодит хөрөнгийн бүртгэлийн үнээс давуулж төлсөн үнэ буюу хөрөнгө оруулагчдын зүгээс компанийн ирээдүйд хэр итгэж байгааг харуулдаг чухал үзүүлэлт юм.

P/E- буюу үнэ ашгийн харьцаа нь тухайн хувьцааны үнэ зах зээл дээр хэр бодитой үнэлэгдэж байгааг тодорхойлдог.



**ШИНЭ ИХ ТЭРБУМ
АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
1-р хороо, 12-р хороолол, North center, 207 тоот
Утас: 9919-9075, 8810-8885, И-мэйл: ikhterbum@gmail.com

2018-03-12 № 18/21
танай _____-ны № _____-т

“ЖЕНКОТУР БЮРО” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.НАМУУН ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “ЖЕНКОТУР БЮРО” ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүү байдлын тайлан, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, компанийн санхүүгийн тайлан нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Аудитын ажлын хүрээнд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана.

Сонгон авсан горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна.

Тэдгээр эрсдлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үйл явц үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзан үзсэн. Мөн аудитын ажилд хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлэх ажлуудыг багтаасан болно.

Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудиторын мэргэжлийн үнэлэмжээр “аудитын гол асуудал” гэдэг нь тайлант жилийн санхүүгийн тайланд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц зүйлс болно. Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан, аудитын ажлын агуулга болон дүгнэлтийн хэлбэрт тусгалаа олсон тул тусгайлсан санал, дүгнэлт гаргаагүй.

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудал

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй.

Компанийн удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

Ийнхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварыг үнэлэх, тодруулга бэлтгэх, компанийг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоох, өөр бусад арга хэмжээ авах зорилгогүй байгаа тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн холбоотой асуудлуудыг тодруулга хэлбэрээр бэлтгэх үүрэг хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах нь бидний үүрэг юм.

Бид аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон түүний тодруулгуудыг нотлох горимуудыг гүйцэтгэх ажил багтдаг. Аудитын явцад компанид хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолол, тайлангууд бодитой эсэхэд дүгнэлт өгсөн болно.



"ЖЭНКОТУР БЮРО" ХК

АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)

ХӨРӨНГӨ

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

| | <i>Лав</i> | 2016.12.31 | 2017.12.31 |
|--------------------------------|------------|--------------------|--------------------|
| Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс | 4 | 10,737,005 | 106,855,608 |
| Дансны ба бусад авлага | 5 | 245,440,245 | 187,352,882 |
| Татвар, НДШ-ийн авлага | 6 | 3,083,983 | 8,441,527 |
| Бараа материал | 7 | 353,240,418 | 332,189,303 |
| Урьдчилж төлсөн тооцоо, зардал | 8 | 224,199,080 | 224,199,080 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | | 836,700,731 | 859,038,400 |

ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

| | | | |
|------------------------------------|----|----------------------|----------------------|
| Үндсэн хөрөнгө | 9 | 7,688,755,863 | 7,276,118,527 |
| Биет бус хөрөнгө | 10 | 567,251,397 | 511,126,430 |
| Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө | 11 | 1,670,689,302 | 1,863,209,627 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | 9,926,696,562 | 9,650,454,584 |

ХӨРӨНГИЙН ДҮН

| | |
|-----------------------|-----------------------|
| 10,763,397,293 | 10,509,492,984 |
|-----------------------|-----------------------|

ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ

БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

| | | | |
|-----------------------------|----|-------------|-------------|
| Дансны ба бусад өглөг | 12 | 694,557,426 | 619,009,044 |
| Татвар, НДШ-ийн өглөг | 13 | 328,274,981 | 336,355,149 |
| Бусад богино хугацаат өглөг | 14 | 593,403,381 | 502,425,459 |

Богино хугацаат өр төлбөрийн дүн

| | |
|----------------------|----------------------|
| 1,616,235,787 | 1,457,789,651 |
|----------------------|----------------------|

УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

| | | | |
|--------------------------------------|----|--------------------|--------------------|
| Урт хугацаат өглөг | 15 | 924,977,901 | 661,903,132 |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | | 924,977,901 | 661,903,132 |

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

| | | | |
|--|----|----------------------|----------------------|
| Хувьцаат капитал | 16 | 8,208,560,402 | 8,208,560,402 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 17 | 706,061,110 | 706,061,110 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | | (692,437,908) | (524,821,311) |
| Хувьцаа эзэмшигчдийн өмчийн дүн | | 8,222,183,604 | 8,389,800,201 |

ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН

| | |
|-----------------------|-----------------------|
| 10,763,397,293 | 10,509,492,984 |
|-----------------------|-----------------------|

Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно

"ЖЭНКОТУР БЮРО" ХК
АУДИТЛАСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

| | <i>Лав</i> | <u>2016.12.31</u> | <u>2017.12.31</u> |
|---|------------|-----------------------------|---------------------------|
| Борлуулалтын орлого | 18 | 1,973,292,677 | 3,462,937,193 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 19 | 1,629,190,503 | 3,011,613,847 |
| Нийт ашиг | | <u>344,102,174</u> | <u>451,323,346</u> |
| Санхүүгийн ба бусад орлого | 20 | 450,261 | 890,045 |
| Үйл ажиллагааны зардал | 21 | 324,899,534 | 235,041,564 |
| Бусад зардал | 22 | - | 38,023,357 |
| Бусад олз, гарз | 23 | (506,708,553) | 9,805,252 |
| Татварын өмнөх ашиг (алдагдал) | | <u>(487,055,652)</u> | <u>188,953,723</u> |
| Орлогын татварын зардал | | 4,556,634 | 21,337,126 |
| Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал) | | <u>(491,612,286)</u> | <u>167,616,596</u> |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | |
| Тайлант жилийн нийт ашиг (алдагдал) | | <u>(491,612,286)</u> | <u>167,616,596</u> |

Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн салиггүй хэсэг болно

"ЖЕНКОТУР БЮРО" ХК

АУДИТЛАСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)

| ҮЗҮҮЛЭЛТ | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | Нийт өмчийн дүн |
|---|----------------------|------------------------|-------------------------------------|-------------------------------|----------------------|
| 2015 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 7,998,880,200 | 209,680,202 | 706,061,110 | (200,825,621) | 8,713,795,891 |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | |
| Ногдол ашиг зарласан | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (491,612,286) | (491,612,286) |
| 2016 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 7,998,880,200 | 209,680,202 | 706,061,110 | (692,437,907) | 8,222,183,605 |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | |
| Ногдол ашиг зарласан | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | 167,616,596 | 167,616,596 |
| 2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 7,998,880,200 | 209,680,202 | 706,061,110 | (524,821,311) | 8,389,800,201 |

Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно

"ЖЕНКОТУР БЮРО" ХК
АУДИТЛАСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

| ҮЗҮҮЛЭЛТ | (Төгрөгөөр) | |
|---|----------------------|----------------------|
| | 2016.12.31 | 2017.12.31 |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | 2,114,101,047 | 3,545,106,367 |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 2,114,101,047 | 3,545,106,367 |
| Бусад | | |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 1,802,362,550 | 3,070,109,860 |
| Ажиллагчдад олгосон мөнгө | 423,638,665 | 386,799,468 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | 64,177,726 | 145,741,000 |
| Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө | 506,051,799 | 1,587,388,755 |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | 70,365,468 | 107,216,200 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 50,931,584 | 32,070,137 |
| Даатгалын төлбөрт төлсөн мөнгө | 432,242 | |
| Төлсөн хүү | 223,890,815 | 192,520,325 |
| Төлсөн татвар | 80,828,697 | 186,749,556 |
| Бусад мөнгөн зарлага | 382,045,554 | 431,624,419 |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 311,738,497 | 474,996,507 |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | 372,739 | 890,045 |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | |
| Урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | | |
| Хүлээн авсан хүүний орлого | 372,739 | 890,045 |
| Хүлээн авсан ногдол ашгийн орлого | | |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 26,326,900 | 28,108,900 |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 26,326,900 | 28,108,900 |
| Биет хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | | |
| Бусад | | |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний дүн | (25,954,161) | (27,218,855) |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | - | - |
| Зээл өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| Хувьцаа үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| Бусад | | |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 269,969,254 | 354,052,691 |
| Мөнгөөр төлсөн ногдол ашиг | | |
| Зээл үнэт цаасны төлбөрт | 269,969,254 | 354,052,691 |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| Бусад | | |
| Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (269,969,254) | (354,052,691) |
| Валютын ханшийн зөрүү | (9,747,950) | 2,393,642 |
| БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 6,067,132 | 96,118,603 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 4,669,872 | 10,737,005 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 10,737,005 | 106,855,608 |

Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно

5. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

5.1.Компанийн ногдол ашиг тараахгүй шийдвэр гаргасан үндэслэл, шийдвэр

“Женко тур бюро” ХК-ийн 2017 оны 12 сарын 31-ээр тасалбал болгосон жилийн эцсийн байдлаар борлуулалтын орлогын төлөвлөгөөний биелэлт 75 хувь буюу 3,46 тэрбум, татварын дараах ашиг 167,6 сая төгрөг байна.

Компаний тухай хуулийн 47-р зүйл, компаний дүрмийн 4.3 болон 4.4-т зааснаар жил болгоны цэвэр ашгийг урт богино хугацааны хөрөнгө оруулалт, компанийн ажиллагсдын нийгмийн асуудал, шагнал, урамшил, компанийн эрх бүхий албан тушаалтанд олгох шагнал урамшуулал зэрэгт төсөвлөх мөн хувьцаа эзэмшигчдэд нийт цэвэр ашгийн 20-оос доошгүй хувийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилна хэмээн заасан байдаг.

Дүрмийн дагуу 2017 оны цэвэр ашгаас ногдол ашигт хуваарилах дүн: **33,5** сая төгрөг Үүнээс нэгж ширхэг хувьцаанд ногдох ашиг: **0.42** төгрөг гарч байна.

Сүүлийн жилүүдэд Монгол улсад ирж буй жуулчдын өсөлтийн хувь эерэг үзүүлэлттэй 2017 онд манай улсад ирсэн гадаад жуулчдын тоо өмнөх онынхоос 16 хувиар өссөн, дотоод аялагчидын идэвхи тоо нэмэгдсэн мөн эдийн засгийн болон аялал жуулчлалын салбарын таатай нөхцөл байдалтай холбогдуулан “Женко тур бюро” ХК нь үйл ажиллагаагаа өргөжүүлэн ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх бүрэн боломжтой харагдаж байна.

Гүйцэтгэх удирдлагын зүгээс энэхүү боломжийг сайтар ашиглахын тулд 2017 оны цэвэр ашгаас “ХШ ЗУУН”, “Чингисийн морьт хөшөө” цогцолборт тодорхой хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж мөн дээрх тооцооллыг үндэслэн хувьцаа эзэмшигчиддээ энэ жил ногдол ашиг хуваарилахгүй байхаар санал оруулж ТУЗ-ийн гишүүдийн эчнээ санал хураалтаар 77.7 хувийн ирцтэйгээр хэлэлцэж гишүүдийн 85.7 хувийн саналаар зөвшөөрснөөр ногдол ашиг тараахгүй гэж шийдвэрлэсэн.



**“ЖЕНКО ТУР БЮРО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 02 сарын 19 өдөр

Дугаар №1.....

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Монгол улсын компаний тухай хуулийн 46-р зүйлийн 46.5 дахь заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Женко тур бюро” хувьцаат компанийн 2017 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Ногдол ашиг хуваарилахгүй байх үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Төлөөлөн удирдлагын дарга /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА / Д.ДАЯНБИЛГҮҮН /

